



**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ**  
(Захиргааны эрх зүйн маргаан)

**7 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙГ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН  
ЗОРИУЛАЛТЫН БУС СУУДАЛД ТЭЭВЭРЛЭЖ БОЛОХГҮЙ**

Анна Петрова зургаан настай хүүхдээ Тойота Камри маркийн автомашинд хүүхдийн зориулалтын суудалгүй тээвэрлэж явсан байна. Автомашины суудалд дэр тавин хүүхдээ дэрэн дээр суулгаж, хамгаалалтын бүс зүүлгэсэн байв. Замын цагдаагийн байцаагч энэ зөрчлийг анзаарч, машиныг зогсоожээ.

Тэрээр Петронад Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12.23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг («Хүн тээвэрлэх дүрмийг зөрчих»)¹ үндэслэн 3000 рубль торгууль ногдуулжээ. Петрова уг шийдвэрийг эс зөвшөөрч, Хабаровск хотын дүүргийн төв шүүхэд хандсан (№ 12-276/2018 хэрэг)². Нэхэмжлэлдээ хүүхдийг машины хамгаалалтын бүс, дэрээр сайн хамгаалсан гэж Петрова дурдсан байна.

Гэвч шүүгч Николай Сидоров Замын Цагдаагийн Байцаагчийн шийдвэртэй санал нэг байгаагаар илэрхийлэв. Анхан шатны шүүх “Замын хөдөлгөөний дүрмийн” 22.9-д зааснаар 7 хүртэлх насны хүүхдийг автомашины зориулалтын суудалд тээвэрлэх ёстойг³ дурдаж, нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас татгалзав.

Петрова энэ шийдвэрийг эсэргүүцэн давж заалдсан боловч анхан шатны шүүхийн шийдвэрийг Хабаровск мужийн шүүх болон ОХУ-ын Дээд шүүх хэвээр үлдээсэн байна. (№ 58-3X 19-4 хэрэг)⁴.

¹ Кодекс Российской Федерации об административных правонарушениях от 30.12.2001 N 195-ФЗ// (ОХУ-ын 2001 оны 12 сарын 30-ны өдрийн “Захиргааны зөрчлийн тухай хууль”) URL: [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_34661/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/)

² Официальный сайт Центрального районного суда г. Хабаровска (дело № 12-276/2018) (Хабаровск хотын дүүргийн төв шүүхийн албан ёсны цахим хуудас (№ 12-276/2018 хэрэг)) URL: [https://centralnyr--hbr.sudrf.ru/modules.php?name=sud\\_delo&srv\\_num=1&name\\_op=case&case\\_id=114445331&case\\_uid=11e64197-2a21-4657-b85f-e53bdb142919&delo\\_id=1502001](https://centralnyr--hbr.sudrf.ru/modules.php?name=sud_delo&srv_num=1&name_op=case&case_id=114445331&case_uid=11e64197-2a21-4657-b85f-e53bdb142919&delo_id=1502001)

³ Постановление Правительства РФ от 23.10.1993 N 1090 "О Правилах дорожного движения"// (ОХУ-ын Засгийн газрын 1993 оны 10-р сарын 23-ны өдрийн N 1090 тогтоол "Замын хөдөлгөөний дүрэм") URL: [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_2709/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_2709/)

⁴ Постановление Верховного суда РФ от 13 мая 2019 года № 58-АД 19-4// (ОХУ-ын Дээд шүүхийн 2019 оны 5-р сарын 13-ны өдрийн 58-3X 19-4 тоот тогтоол) URL: [http://vsrf.ru/stor\\_pdf.php?id=1768608](http://vsrf.ru/stor_pdf.php?id=1768608)



**Анхааруулга:** ОХУ-ын 2006 оны 7-р сарын 27-ны өдрийн № 152 "Хувийн мэдээллийн тухай" хуулийн 7 дугаар зүйлд "Хувийн мэдээлэлд нэвтрэх эрхтэй операторууд болон бусад этгээдүүд ОХУ-ын хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр түүний хувийн мэдээллийг гуравдагч этгээдүүдэд задруулахгүй, бусдад тараахгүй байх үүрэгтэй"<sup>5</sup> гэж зааснаар тус шийдвэрийг орчуулахдаа автомашины марк, хүний нэрийг өөрчилж бичсэн болно.

**Орчуулсан: С. Жансая**  
**Шүүхийн сургалт, судалгаа,**  
**мэдээллийн хүрээлэнгийн**  
**Үндсэн хууль, олон улсын эрх зүйн**  
**судлаач**

-oOo-

---

<sup>5</sup> ст. 7 Федерального закона "О персональных данных" от 27.07.2006 N 152-ФЗ (последняя редакция)// (ОХУ-ын 2006 оны 7-р сарын 27-ны өдрийн № 152 "Хувийн мэдээллийн тухай" хуулийн 7 дугаар зүйл)  
URL:[http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_61801/a15bab6050028753706f22c32fe60627a7be79f9/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_61801/a15bab6050028753706f22c32fe60627a7be79f9/)